

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 24 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2024-10

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд
бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, Банкны тухай хуулийн 29.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны Дүрмийн 8.16 дахь хэсэгт заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн бүрэн эрх 2 жилийн хугацаатай бөгөөд одоогийн ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа нь Банкны хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит хурлын өдрөөр дуусгавар болохыг;
- ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журмын 5.1 дэх хэсэгт заасны дагуу Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо ("ЗНДЦУХ") нь Банкны хувьцаа эзэмшигчдэд 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн зөвлөмжөөрөө Банкны ТУЗ-ийн 12 орон тоонд нэр бүхий нэр дэвшигчдийг санал болгосныг; мөн
- Хувьцаа эзэмшигчид нь кумулятив аргаар хураасан санал хураалтын үр дүнг тодорхойлсон Тооллогын комиссын шийдвэрт үндэслэн, дараах нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдээр сонгохыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Дараах нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдээр сонгосугай:
 - Албертус Браггинк;
 - Анджей Витак;
 - Доминик Жак;
 - Майкл Мадден;
 - Сюзанна Карр;
 - Санжай Гүпта;
 - Гүмэнжавын Цэвэгжав;
 - Нямтайширын Цэлмүүн;
 - Нираж Вэдва;
 - Стюарт Холл;
 - Баянсаны Уламбаяр;
 - Эми Чой (Лай Фун Чой).
- Шинээр сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлж, энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай эсхүл зохих арга

хэмжээ авч ажиллахыг Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт даалгаж, холбогдох эрхийг олгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА